



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.12 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй хавсралтад дурдсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хуулийн этгээдийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасан хугацаанд шүүхэд гомдол гаргах боломжтой болохыг дурдсугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
99 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөр- лийн дугаар	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	"Бодь пропертийз" ХХК	12100666	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
2	"Эн эс би жи" ХХК	12100683	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
3	"Мазаалай маржинг" групп ХХК	12100689	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
4	"Инкон" ХХК	12100698	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх

----- оОо -----